

**НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ТӨРИЙН ЗАРИМ
ЧИГ ҮҮРГИЙГ ГҮЙЦЭТГЭХ САНГИЙН ЯАМНЫ
109 ТООТ ГЭРЭЭ ДҮГНЭСЭН АКТ***

2019 оны 12 дугаар сарын-ны өдөр

1. ЕРӨНХИЙ ЗААЛТ

Гэрээний нэр	Нягтлан бодох бүртгэлийн төрийн зарим чиг үүргийг гүйцэтгэх	
Гэрээний дугаар	109	
Захиалагч байгууллага	Монгол Улсын Сангийн яам	
Захиалагч байгууллагын төлөөлөх эрх бүхий нэгж	Сангийн Яамны Нягтлан бодох бүртгэлийн бодлогын газар	
Гүйцэтгэгч байгууллага	Монголын Мэргэшсэн Нягтлан Бодогчдын Институт	
Гэрээгээр ажил эхлүүлсэн хугацаа	2016 оны 6-р сарын 02 2017 оны 12-р сарын 31	
Гэрээг сунгасан хугацаа	2017 оны 12 дугаар сарын 15 наас 2020 оны 12 дугаар сарын 15 хүртэл	
Гэрээг дүгнэх хугацаа	2019 оны 12 дугаар сарын 05	
Товчилсон үгийн тайлбар	АОУС	Аудитын олон улсын стандарт
	НБББГ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын газар
	СТОУС	Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт

2. ГЭРЭЭНИЙ БИЕЛЭЛТ

2.1. Гэрээний тусгай нөхцөлийн биелэлт

Гэрээний тусгай нөхцөл	Биелэлт	Хувь
2.1.1 Мэргэшсэн нягтлан бодогчийн эрх олгох, сунгах шалгалт, сургалт зохион байгуулах, аудитын үйл ажиллагааны стандарт, мэргэжлийн ёс зүйн дүрмийг	<p>Мэргэшсэн Нягтлан Бодогч (МНБ)-ийн эрх олгох сургалтын хүрээнд:</p> <ul style="list-style-type: none"> - Мэргэшсэн Нягтлан Бодогчийн эрх олгох шалгалтанд бэлтгэх Санхүүгийн тайлагнал, Өртөг гүйцэтгэлийн удирдлага, Санхүүгийн менежмент, Аудит ба баталгаажуулалт, Хууль эрх зүй, татварын бүртгэл, Мэргэжлийн англи хэл гэсэн 6 чиглэлээр сургалтыг Улаанбаатар хот болон 21 аймагт 67 удаа зохион байгуулан 1675 хүн хамруулсан. - Мэргэшсэн Нягтлан Бодогчийн эрх олгох сорил шалгалтанд бэлтгэх Ёс зүй, Мэдээллийн Технологи, Санхүүгийн тайлан 	91%

зөрчсөн
аудиторын
мэргэшсэн
нягтлан
бодогчийн эрхийг
хүчингүй болгох;

бэлтгэх арга зүй гэсэн 3 чиглэлээр 1195 хүнд сургалт болон шалгалт зохион байгуулсан.

Мэргэшсэн Нягтлан Бодогчийн эрх сунгах болон тасралтгүй хөгжлийн сургалтын хүрээнд:

- МНБ-ийн эрхийг 4 жилээр болон хугацаагүйгээр сунгах 6 удаагийн сургалтанд нийт 352 хүн хамрагдсан.
- ХААН банк, Эрчим хүчний хөгжлийн төв Төрийн Өмчит Үйлдвэрийн Газар, Дулааны Цахилгаан Станц-4, “Багануур зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ” Төрийн Өмчит Хувьцаат Компани, Эрдмийн их сургууль, Улсын Ерөнхий Прокурор, Таван богд групп, Өвөрхангайн аймгийн Засаг даргын Тамгын газар гэсэн 8 байгууллага болон аж ахуйн нэгжийн захиалгат сургалтыг зохион байгуулан 313 хүн хамрагдсан.
- Мэргэжлийн болон хувь хүний хөгжлийн орчин үеийн чиг хандлагын талаарх дараах сэдвүүдээр тасралтгүй хөгжлийн сургалтыг нийт 568 МНБ-дод Улаанбаатар хотод зохион байгуулсан. Үүнд:
 - Нягтлан бодох бүртгэлийн ирээдүйн чиг хандлага,
 - Татварын хуулийн шинэчлэл,
 - МНБ-ийн мэргэжлийн болон хувь хүний өсөлт, хөгжил,
 - Дижитал шилжилт,
 - Компанийн засаглал, засаглалын үндсэн зарчимууд,
 - Монгол Улсын төсөв, мөнгөний бодлогын өнөөгийн байдал,
 - Power BI хэрэгслийн хэрэглээ,
 - Дотоод хяналтын тогтолцоо, дотоод аудитын тухай ойлголт,
 - Нягтлан бодох бүртгэлийн мэргэжилд хиймэл оюун ухааны үзүүлж буй нөлөө, хөдөлгөөнт орчин дахь мэдээллийн системийн аудит,
 - Хувь хүний хөгжил,
 - Танин мэдэхүйн гажуудал,
 - “Бага төрөлт”-ийн эдийн засаг, санхүү, нийгэмд үзүүлэх нөлөө,
 - Бизнес зөв шийдвэр гаргахад удирдлагын тайланг ашиглах нь,
 - Саарал жагсаалт гэж юу вэ? Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэхэд бид ямар оролцоотой вэ?
 - Системийн инженерчлэлийн аргаар байгууллагын эрүүл мэндийг оношилж эмчлэх шийдэл,
 - Ёс зүйтэй нягтлан бодогч,
 - Санхүүгийн зөвлөх үйлчилгээ, хөгжлийн чиг хандлага,
 - Ёс зүйн манлайлал,
 - СТОУС-ын өөрчлөлт шинэчлэлт,
 - Мэргэжлийн ёс зүй.

	<ul style="list-style-type: none"> - Мөн мэргэжлийн тасралтгүй хөгжлийн сургалтын хүрээнд Ховд аймагт “Баруун бүс”-ийн сургалт, зөвлөгөөнийг зохион байгуулан Завхан, Говь-Алтай, Увс, Баян-Өлгий, Ховд аймгуудын 240, Орхон аймагт “Хойд бүс”-ийн сургалт, зөвлөгөөнийг зохион байгуулан Сэлэнгэ, Дархан, Булган, Хөвсгөл, Орхон аймгуудын 504, нийт 744 мэргэшсэн болон мэргэжлийн нягтлан бодогчид тус тус хамрагдсан. <p>Мэргэшсэн Нягтлан Бодогчийн эх олгох сургалтын онлайн орчин бүрдүүлэх</p> <ul style="list-style-type: none"> - Мэргэшүүлэх сургалтын Санхүүгийн бүртгэл, Зардлын бүртгэл гэсэн 2 хичээл, МНБ-ийн эрх олгох сургалтын Санхүүгийн менежмент 1 хичээл, нийт 3 хичээлийн онлайн сургалтын бичлэгүүд хийгдэж бүрэн дууссан. - Англи хэлний 6 сарын хугацаатай, иж бүрэн 10 түвшний 24/7 платформтой гэрээлж гишүүдийн зайнаас бие даан суралцах боломжийг бүрдүүлсэн. - МНБ-ийн эрх олгох-Хууль, татварын бүртгэл хичээлийн шалгалтыг онлайнаар авах бэлтгэлийг хангаж тестийн сан болон программ хангамжийг бүрэн шийдвэрлэсэн. <p>Мэргэшсэн Нягтлан Бодогчийн эрх олгох шалгалт</p> <ul style="list-style-type: none"> - Сангийн сайдын тушаалаар батлагдсан МНБ-ийн эрх олгох шалгалтын комисс МНБ-ийн эрх олгох шалгалтыг Улаанбаатар хот болон 21 аймагт 2019 онд хавар болон намар 2 удаа зохион байгуулсан. МНБ-ийн эрх олгох хаврын шалгалтанд 1180 шалгуулагч орсноос 154 хүн шинээр МНБ болж тангараг өргөсөн. МНБ-ийн эрх олгох намрын шалгалтанд 1213 шалгуулагч орсон. <p>Аудитын стандарт, ёс зүйн дүрмийн зөрчилтэй холбоотой</p> <ul style="list-style-type: none"> - МНБ-ийн ёс зүйн дүрмийн зөрчилтэй холбоотой 8 гомдол, 2 хүсэлт ирснийг “МНБ-ийн ёс зүйтэй холбоотой өргөдөл, гомдол хүлээн авах, шалгах, шийдвэрлэх журам”-д заасны дагуу шаардлагатай баримт, нотолгоог бүрдүүлэн ММНБИ-ийн Ёс зүйн хяналт шалгалтын дэд хорооны хурлаар хэлэлцүүлж дүгнэлт гарган ММНБИ-ийн Удирдах зөвлөлд хүргүүлсэн. - Ёс зүйн хяналт шалгалтын дэд хорооны дүгнэлтийг үндэслэн ММНБИ-ийн Удирдах зөвлөлийн хурлаар аудитын 5 хуулийн этгээдэд ажиллаж байсан 17 аудиторын “Аудит ба баталгаажуулах үйлчилгээ эрхлэх эрхийн батламж”-ийг хүчингүй болгож, 6 МНБ-дод “Сануулах” сахилгын шийтгэл, 1 МНБ-ийн эрхийг хүчингүй болгох тогтоол гаргасан. 	
2.1.2 Мэргэшсэн нягтлан бодогч, аудиторын ёс зүйн	ММНБИ-ийн Удирдах зөвлөлийн 2016 оны 11-р сарын 29-ны өдрийн хурлаар батлагдсан “Монгол Улсын Мэргэшсэн Нягтлан Бодогчдын Ёс зүйн дүрэм”-ийн хэрэгжилтийг ханган	100%

<p>дүрмийг батлах, хэрэгжилтэд нь хяналт тавих;</p>	<p>ажиллаж буй 73 аудитын компанид Ёс зүйн тодорхойлолтыг гаргаж дараах байгууллагуудад хүргүүлсэн. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - Сангийн яам 27, - Санхүүгийн зохицуулах хороо 4, - Үндэсний аудитын газар 42. 	
<p>2.1.3 Нягтлан бодох бүртгэл, аудитын олон улсын стандарт, түүний нэмэлт, өөрчлөлтийг орчуулах, хэрэглэх, тайлбар, зөвлөмж боловсруулан гаргах, аж ахуйн нэгж байгууллагын стратеги засаглал, гүйцэтгэл, хэгийн хандлагын уялдааг харуулсан бусад тайлагналын аргачлалыг боловсруулах;</p>	<p>Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Зөвлөл (НББОУСЗ)-өөс батлан гаргадаг Иж бүрэн Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт 2018 (Full International Financial Reporting Standards 2018)-ын 1496 хуудас бүхий Монгол орчуулгын хянагдсан хувилбарыг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (СТОУС) Сан болон Сангийн сайдын дэргэдэх Нягтлан бодох бүртгэл, аудитын хороогоор эцэслэн хянуулж зөвшөөрөл аван 500 ширхгийг хэвлэн гаргаж нийтийн хүртээл болгосон.</p> <p>Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (СТОУС) ба Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт (УСНББОУС)-ын сургагч багш бэлтгэх хөтөлбөрийг боловсруулан Сангийн яамны Нягтлан бодох бүртгэлийн бодлогын газарт хүргүүлсэн. Уг хөтөлбөр нь Сангийн сайдын дэргэдэх Нягтлан бодох бүртгэл, аудитын стандартын хорооны 2019 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн 08 тоот тогтоолоор батлагдсан.</p> <p>Дэлхийн Банкны санхүүжилтгэйгээр Англи, Уэлсийн итгэмжлэгдсэн нягтлан бодогчдын институт (ICAEW), Монгол Улсын Сангийн яам хамтран 2019 оны 08 сарын 12-16-ны хооронд зохион байгуулсан бизнесийн болон улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын сургагч багш бэлтгэх сургалтад ММНБИ-ээс 4 хүн хамрагдаж Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (СТОУС) болон Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт (УСНББОУС)-ын сургагч багшийн эрхийг авсан.</p> <p>Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (СТОУС) 16 Түрээс ба Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (СТОУС) 17 Даатгалын гэрээ стандартуудын аргачлалыг боловсруулах ажлын хүрээнд их, дээд сургуулиудын судлаачидтай хамтран эдгээр стандартыг хэрэглэх аргачлалыг боловсруулан Сангийн яамны Нягтлан бодох бүртгэлийн бодлогын газарт хүргүүлсэн. Эдгээр аргачлал нь Нягтлан бодох бүртгэл, аудитын хороогоор хэлэлцэгдэж үндэсний стандарт болох ажил хийгдэж байна.</p> <p>Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (СТОУС) 3 Бизнесийн нэгдэл стандартад орсон өөрчлөлтийг Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Зөвлөл (НББОУСЗ)-өөс 2019 оны 10 сарын 22-нд эцэслэн баталсан. Уг</p>	<p>95,7%</p>

	<p>өөрчлөлтийг орчуулан, хянаж 2019 оны 11 сарын 14-нд ММНБИ-ийн цахим хуудсанд байршуулан гишүүд, олон нийтийн хүртээл болгосон.</p>	
<p>2.1.4 Аудитын хуулийн этгээдийг мэргэжил, арга зүйн удирдлага, зөвлөгөө, мэдээллээр хангах;</p>	<p>Мэргэжлийн эрхийн хяналтын дэд хорооноос 2019 онд Аудитын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн шаардлага хангасан дараах 9 компанийг Сангийн яаманд уламжилсан.</p> <ul style="list-style-type: none"> - Хоо Өрлөгийн Үрс ХХК, - Эн Би Эм Жи ХХК, - Солид Юнити ХХК - Ирмүүн Хантайшир ХХК, - Этернал Секвил ХХК, - Энх Мөнх Сод Эрдэнэ ХХК, - ЦЭБЭ консалтинг ХХК, - Кой ХХК, - Аккоунт траст ХХК. <p>Аудитын компаниудын захирал, гишүүдийг мэргэжил арга зүй зөвлөгөө мэдээллээр хангах зорилгоор дараах 4 сэдвийн хүрээнд сургалт зохион байгуулж нийт 295 аудитор, гишүүдийг хамрууллаа. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - Боловсролын олон улсын стандарт 8 Санхүүгийн тайлангийн аудит хариуцсан гэрээт ажлын партнерын мэргэжлийн чадавх сэдвээр 86 хүн, - Эрсдэлд суурилсан аудит сэдвээр 35 хүн, - Нягтлах гэрээт ажлын олон улсын стандарт сэдвээр 90 хүн, - Аудитын олон улсын стандартын өөрчлөлт сэдвээр 84 хүн тус тус хамрагдсан. <p>Аудитын чанарын хяналтын талаар</p> <p>Аудитын компаниудад чанарын хяналт хийх ажлын хэсгийн бүрэлдэхүүнд ажиллуулахаар дэд захирал Л.Батцэнгэл, менежер М.Жавхлан нарыг нэр дэвшүүлж Сангийн яаманд хүргүүллээ. Мөн хяналт шалгалтад хамруулах саналтай аудитын 31 компанийн нэрсийг гарган Сангийн яаманд хүргүүлсэн.</p> <p>Сангийн сайдын тушаалаар батлагдсан “Аудитын чанарын хяналт хийх ажлын хэсэг”-ийн бүрэлдэхүүнд орж ажиллан гадны зөвлөхийн хамт 3 аудитын компани дээр чанарын хяналт шалгалт хийж гүйцэтгэсэн. 2019 оны 10 дугаар сарын 14-ны өдрөөс эхлэн хуваарийн дагуу чанарын хяналт шалгалтын ажлыг хийж гүйцэтгэж байна.</p>	<p>100%</p>

*Тайлбар: “Нягтлан бодох бүртгэлийн төрийн зарим чиг, үүргийг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх” СЯ 109 тоот гэрээний үүргийн хэрэгжилтийн дэлгэрэнгүйг энэхүү гэрээ дүгнэсэн актын хавсралтаас үзнэ үү.

Нийт нийлбэр дүнгээр гэрээний үүргийн биелэлт 96,6 % (ерөн зургаа аравны зургаан хувь) гэж хоёр тал харилцан тохиролцов.

ГЭРЭЭ ДҮГНЭСЭН:

Захиалагчийг төлөөлж:

САНГИЙН САЙД:
Ч.ХҮРЭЛБААТАР



САНГИЙН ЯАМНЫ НЯГТЛАН
БОДОХ БҮРТГЭЛИЙН БОДЛОГЫН
ГАЗРЫН ДАРГА:
Ч.ЧИМИДСҮРЭН

САНГИЙН ЯАМНЫ НЯГТЛАН
БОДОХ БҮРТГЭЛИЙН БОДЛОГЫН
ГАЗРЫН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН:
Д.ДАРИЙМАА

Гүйцэтгэчийг төлөөлж:

МОНГОЛЫН МЭРГЭШСЭН НЯГТЛАН
БОДОГЧДЫН ИНСТИТУТИЙН
ЕРӨНХИЙЛӨГЧ
Б.ТУВИНШИН



МОНГОЛЫН МЭРГЭШСЭН НЯГТЛАН
БОДОГЧДЫН ИНСТИТУТИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
Д.НАЦАГДОРЖ

ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА
Г.БИЛЭГ-ӨРНӨХ